



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/367


Улаанбаатар хот

Өрхийн эрүүл мэндийн төвийг
сонгон шалгаруулах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах журам”-ыг мөрдлөг болгон ажиллахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/367 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141241284

Эрүүл мэндийн сайдын 2024 онь 07
дугаар сарын 08 өдрийн А/321
дугаар тушаалын хавсралт

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журам нь хот, суурин газрын хүн амд өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх Өрхийн эрүүл мэндийн төвийн багийг (цаашид “баг” гэх) сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Сонгон шалгаруулалтын зорилго нь харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх Өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр байгуулах, өмнө үйл ажиллагаа гүйцэтгэж байсан Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээ цуцлагдсан, гэрээг сунгах эрх үүсээгүй тохиолдолд багийг сонгон шалгаруулахад оршино.
- 1.3. Сонгон шалгаруулалт нь Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Нөхөрлөлийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Зөрчлийн тухай хууль, энэхүү журам болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.

Хоёр. Сонгон шалгаруулалтын зарчим

- 2.1 Сонгон шалгаруулалтад дараах зарчим баримтална. Үүнд:
 - 2.1.1. Үр ашигтай байх: Харьяа хүн амын эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээнд нийцсэн чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;
 - 2.1.2. Чадамжид суурилсан байх: Сонгон шалгаруулалт нь тусламж, үйлчилгээ үзүүлэх багийн чадамж, хүртээмжийн талаарх бодит үнэлгээнд суурилсан байх;
 - 2.1.3. Хүлээн зөвшөөрсөн байх: Сонгон шалгаруулалтад хамрагдах хүсэлт гаргасан тусламж, үйлчилгээ үзүүлэх баг нь “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт” болон бусад холбогдох журам, зааврыг мөрдөх;
 - 2.1.4. Ил тод, нээлттэй байх: Сонгон шалгаруулалт нь ил тод, нээлттэй явагдах бөгөөд үр дүнг олон нийтэд мэдээлэх;
 - 2.1.5. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх: Сонгон шалгаруулалт нь цахим технологид суурилсан, үнэлгээний хорооны гишүүдийн албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байх.

Гурав. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

3.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5.3.-т заасны дагуу Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн байршил, үйлчлэх хүрээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, төлөвлөлтийн хүрээнд нийцүүлэн хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шинээр өрхийн эрүүл мэндийн төв байгуулах шийдвэрийг аймаг, нийслэлийн Засаг дарга гарган сонгон шалгаруулалтын үнэлгээний хороог томилно.

3.2. Сонгон шалгаруулалтыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран зохион байгуулж болно.

3.3. Сонгон шалгаруулалтын бэлтгэл хангах, зохион байгуулах, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж гаргах үндсэн нэгж нь үнэлгээний хороо байна.

3.3.1. Үнэлгээний хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.3.1.1. Сонгон шалгаруулалтын урилга, баримт бичгийг боловсруулах, захиалагчаар батлуулах;

3.3.1.2. Урилгыг нээлттэй зарлуулах;

3.3.1.3. Сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээдийн баримт бичгийг хүлээн авах;

3.3.1.4. Хуулийн хугацаанд тендерийг нээх;

3.3.1.5. Ирүүлсэн баримт бичгийг хянан үзэх, үнэлэх;

3.3.1.6. Захиалагчид шийдвэр гаргах зөвлөмж хүргүүлэх.

3.4. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар сонгон шалгаруулах үнэлгээний хороог томилно.

3.5. Сонгон шалгаруулалт хийх үнэлгээний хороо нь 9-өөс доошгүй сондгой тооны гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд дараах төлөөллийг заавал оролцуулна. Үүнд:

3.5.1. Үйлчлэх хүрээний хүн амын төлөөлөл;

3.5.2. Эрүүл мэндийн газрын анхан шатны тусламж, үйлчилгээний асуудал хариуцсан холбогдох албан тушаалтан;

3.5.3. Өрхийн анагаах ухааны чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлдэг төрийн бус байгууллагын төлөөлөл.

3.6. Сонгон шалгаруулалтын үнэлгээний хороо нь энэхүү журмын 3.1-т заасан сонгон шалгаруулалттай холбогдох үндсэн чиг үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.6.1. Сонгон шалгаруулалтыг аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид, сонгон шалгаруулалтад оролцогч өрхийн эрүүл мэндийн баг, түүний удирдлага, Аймаг, нийслэлийн засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн газар, харилцаанд оролцогч бусад талуудаас хараат бус, бие даасан байдлаар энэхүү журмын 1.3-т заасан холбогдох хууль журмын дагуу зохион байгуулах;

3.6.2. Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагад болон бусад этгээдэд задруулахгүй байх;

3.6.3. Үнэлгээний хороо нь үйл ажиллагаагаа хурлын хэлбэрээр зохион байгуулж тэмдэглэл хөтөлж баримтжуулсан байх;

3.6.4. Сонгон шалгаруулалтын явц, үр дүнд үүссэн санал, хүсэлт, гомдол, маргааныг хуулийн хүрээнд шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх,

3.6.5. Сонгон шалгаруулалтын явцад үүссэн баримт бичгийг хадгаламжийн нэгж үүсгэн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын архивд, хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүлээлгэж өгнө.

Дөрөв. Сонгон шалгаруулалт зохион байгуулах хугацаа, нөхцөл

4.1. Сонгон шалгаруулалтыг шаардлагатай тохиолдолд зохион байгуулна.

4.2. Өрхийн эрүүл мэндийн гэрээний хэрэгжилтийн дүгнэлтээр "хангалтгүй" үнэлгээ авч гэрээ цуцалсан өрхийн эрүүл мэндийн төвийн нөхөн сонгон шалгаруулалтыг тухайн жилийн 1 дүгээр улиралд "Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам"-д заасан хугацаанд зохион байгуулна.

4.3. Шинээр байгуулагдах өрхийн эрүүл мэндийн төвийн сонгон шалгаруулалтын хугацааг Аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

Тав. Сонгон шалгаруулалтад оролцогч багт тавигдах шаардлага

5.1. Сонгон шалгаруулалтад оролцогч баг нь "Ерөнхий шаардлага" болон "Тусгай шаардлага" гэсэн үндсэн 2 төрлийн шаардлагыг хангасан байна.

5.2. "Ерөнхий шаардлага" нь сонгон шалгаруулалтад оролцогч нийт багт нийтлэг тавигдах доорх шаардлагууд байна. Үүнд:

5.2.1. Сонгон шалгаруулалтад оролцох баг нь Нөхөрлөлийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд байх;

5.2.2. Нөхөрлөлийн гишүүдийн хурлын тэмдэглэл эх хувиар байх;

5.2.3. Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэмд заасны дагуу төвийн даргад тавигдах шаардлага, хангасан төвийн даргыг томилж, сонгон шалгаруулалтад оролцох;

5.2.4. Нийгмийн даатгалын шимтгэл тогтмол төлсөн, сонгон шалгаруулалтын материал хүлээн авах цаг хугацаанд шимтгэлийн өргүй байх;

5.2.5. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авч үнэлгээ хийгдэж эхлэх өдрийн байдлаар татварын өргүй байх;

5.2.6. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах цаг хугацаанд шүүхийн шийдвэрээр албадан хэрэгжүүлэх арга хэмжээгүй байх;

5.2.7. Сонгон шалгаруулалтад оролцох баг нь ямар нэг үйл ажиллагаа давхар эрхэлдэггүй байх, эсвэл эрхэлж байсан бол зээл, өр авлагагүйг илэрхийлэх баримт, нотолгоог хавсаргасан байх;

5.2.8. Баг нь Өрхийн эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байх. Төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгасан байх. Үүнд:

5.2.8.1. Стратегийн зорилго, зорилтыг тодорхойлсон байх;

5.2.8.2. Байгууллагын эрхэм зорилго, хүн амын хамрах хүрээ, үйлчлэх хүн амын эрүүл мэндийн байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, үйл ажиллагааны зорилтот түвшин, түүнд хүрэх үйл явц, цогц арга хэмжээг тодорхойлсон байх;

5.2.8.3. Байгууллагын үйл ажиллагааг мэдээллийн технологи, маркетинг, санхүүгийн удирдлагад суурилан удирдан явуулахаар төлөвлөсөн байх;

5.2.8.4. Төвийн хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байх;

5.2.8.5. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг батлагдсан журмын дагуу боловсруулж, магадлан итгэмжлэлд хамрагдах асуудлыг тусгасан байх;

5.2.8.6. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороотой хамтран ажиллах төлөвлөгөөтэй байна.

5.3. "Тусгай шаардлага"-д сонгон шалгаруулалтад оролцогч багийн "Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам"-ын дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадавхтай хүний нөөцөд тавигдах шаардлага багтана. Үүнд:

5.3.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эмчлэх, сувилах, сэргээн засах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;

5.3.2 Өмнө ажиллаж гэрээ цуцлагдсан болон гэрээ сунгах эрх үүсээгүйн улмаас татан буугдсан багийн даргыг нөхөн сонгон шалгаруулалтад орох багийн даргаар томилохгүй байх;

5.3.3. Сонгон шалгаруулалтад орох багийн гишүүд өмнө нь гэрээ цуцлагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн багийн гишүүнээр ажиллаж байсан тохиолдолд багийн бүрэлдэхүүний 60 хувиас ихгүй байх.

5.4. Хүний нөөцийг бүрдүүлэхэд дараах чиглэлийг баримтална. Үүнд:

5.4.1. Багт ажиллах өрхийн эмчийн 50-с доошгүй хувь нь өрхийн анагаах ухаан судлалаар эсвэл ерөнхий мэргэшил судлалаар мэргэшсэн болон ерөнхий мэргэжлийн эмч байх;

5.4.2. Багийн эмч мэргэжилтний бусад 50 хувийг ерөнхий мэргэжлийн эмч, уламжлалт анагаах ухаан, хүүхэд судлал, дотор судлал, эх барих, сэргээн засах, эмэгтэйчүүд судлалын чиглэлээр мэргэшсэн эмч бүрдүүлж болно

5.4.3. Өдрийн эмчилгээний сувилагч, дархлаажуулалтын сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сэргээн засах эмчилгээний сувилагч, лавлагаа мэдээллийн сувилагч, дүн бүртгэл хариуцсан мэргэжилтэнтэй байна.

5.4.4. Нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр суралцаж, мэргэшсэн бол давуу тал болно.

5.4.5. Шүдний эмч, хөдөлгөөн засалч, сэтгэл судлаачийг гэрээгээр ажиллуулж болно.

5.4.6. Багт нягтлан бодогч, жолооч, үйлчлэгч, бусад аж ахуйн албаны ажилтныг гэрээгээр ажиллуулж болно.

Зургаа. Сонгон шалгаруулалт зарлах

6.1. Сонгон шалгаруулалтын урилгыг "Сонгон шалгаруулалт"-ын материалыг хүлээн авч эхлэх өдрөөс ажлын 10-с доошгүй хоногийн өмнө Төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй цахим хуудас болон олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд байршуулна.

Долоо. Сонгон шалгаруулалтын үе шат

7.1. Сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

7.1.1. Сонгон шалгаруулалтад оролцох Өрхийн эрүүл мэндийн төвийн багийн хүсэлт, баримт бичгийг сонгон шалгаруулалтын урилгын 10 хоног дууссаны дараа ажлын 5 хоногийн хугацаанд хүлээн авах;

7.1.2. Сонгон шалгаруулалтын үнэлгээг Өрхийн эрүүл мэндийн төвийн багийн хүсэлт, баримт бичгийг хүлээн авч дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор багтаан танхимаар зохион байгуулах;

7.1.3. Сонгон шалгаруулалтыг "Ерөнхий болон тусгай шаардлага"-ын дагуу ирүүлсэн материалыг холбогдох төрийн захиргааны байгууллагаас урьдчилан цуглуулсан мэдээлэлтэй харьцуулах замаар үнэлгээг хийх;

7.1.4. "Ерөнхий болон тусгай шаардлага"-аас аль нэг шаардлагыг хангаагүй тохиолдолд тэнцээгүйд тооцох;

7.1.5. "Ерөнхий болон тусгай шаардлага"-ыг бүрэн хангасан 2 буюу түүнээс дээш баг шалгарсан тохиолдолд үнэлгээний хорооны гишүүдийн олонхын саналаар 1 багийг шалгаруулж тэнцэнд тооцох;

7.1.6. Сонгон шалгаруулалтад тэнцсэн багийн мэдээллийг захиалагчид зөвлөмжөөр хүргүүлнэ.

7.1.7. Сонгон шалгаруулалтын эцсийн үр дүнг үнэлгээний хороо аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.

Найм. Сонгон шалгаруулалттай холбогдох маргааныг шийдвэрлэх

8.1. Сонгон шалгаруулалтад оролцогч нь сонгон шалгаруулалтын үйл явц, үр дүнгийн талаар Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газраас тодруулга авах, хуульд өөрөөр заагаагүй бол сонгон шалгаруулалтын мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд зөрчлийн нотлох баримтыг хавсаргана.

8.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар нь сонгон шалгаруулалтад оролцогчоос гаргасан сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг хүлээн авснаас хойш түүнийг гомдол барагдуулах ажиллагаанд оролцохыг урина. Гомдол гаргагч нь уг ажиллагаанд оролцоогүй тохиолдолд цаашид гомдол гаргах эрхгүй.

Ес. Хариуцлага

9.1. Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас сонгон шалгаруулалтын явц, үр дүнд нөлөөлсөн нь нотлогдсон бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.2. Өрхийн эрүүл мэндийн баг нь хуурамч баримт бичиг бүрдүүлж сонгон шалгаруулалтад оролцсон нь тогтоогдсон бол тухайн багтай байгуулсан гэрээг цуцалж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

-----oO-----